



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 11 сарын 07 өдөр

Дугаар 03/50

Баян-Өндөр сум

Аймгийн хэмжээнд 2026 онд цэргийн албыг
биеэр дүйцүүлэн хаах иргэдийн тоог
батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 80 дугаар тогтоолоор батлагдсан "Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах журам" -ын 1.5 дахь заалт, 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн "Цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн тооны дээд хязгаарыг тогтоох тухай" 241 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Аймгийн хэмжээнд 2026 онд цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдийн тоог 30 хүнээр баталсугай.

2.Аймгийн 2027 онд цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн тооны дээд хязгаарын саналыг хуулийн хугацаанд Батлан хамгаалах яаманд хүргүүлж ажиллахыг аймгийн Цэргийн штабын дарга, хурандаа Ч.Энхбаярт даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХБАТ

6125010137